

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ 2023 ОНЫ 01 ДҮГЭЭР
САРЫН 10-НЫ ӨДӨР /МЯГМАР ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ТОВЬЁГ**

№	Баримтын агуулга	Хуудас
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-7
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл	8-69
	1.Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	12-22
	2.Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	22-45
	3.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	45-56
	4.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	56-59
	5.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	59-64
	6.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	64-67
	7.“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /Төрөөс олгох урамшууллаас нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуулийн төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий/	67-68
	8.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы 2023 оны 01 дүгээр сард Нийгмийн бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/	68-69

ХУРАЛДААНЫ ТОВЧ ТЭМДЭГЛЭЛ

Тав.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аюурсайхан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, мөн газрын ахлах шинжээч С.Орхон, Б.Гэрэлсайхан, ахлах мэргэжилтэн Ө.Бодьгэрэл, Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг, мөн газрын Санхүү бүртгэлийн газрын дарга Б.Даваахүү нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аюурсайхан танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаагийн тавьсан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аюурсайхан хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен үг хэлэв.

П.Анужин: Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	4
Бүгд:	10

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Монгол Улсын ЗГ-аас 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж төлбөрийн тухай хуулийн

шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэхийг хэлэлцэнэ.

Хуулийн төслийн танилцуулгыг ХНХ-ын сайд Төмөрбаатарын Аюурсайхан хийнэ.

Т.Аюурсайхан: Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийг 1994 онд баталснаас хойш 28 жилийн хугацаанд шимтгэл төлөх зардал гаргах, урьдчилан сэргийлэх асуудлаар уг хуульд 4 удаа нэмэлт, өөрчлөлт орсон.

Үйлдвэрлэлийн ослыг бүртгэх, хяналт тавих, осолд өртсөн болон мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагчид эрүүл мэндийн нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх замаар хөдөлмөрийн чадварыг сэргээх, хөдөлмөрийн зах зээлд эргүүлэн оруулах, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх зэрэг асуудлуудыг шийдвэрлэх шаардлага тавигдаж байна.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, ХАБ, эрүүл ахуйн сургалт сурталчилгааны ажлыг нийгмийн даатгалын байгууллага, төрийн болон хувийн хэвшлийн сургалтын байгууллагаар дамжуулан зохион байгуулж ирсэн. Цаашид сургалтыг үр дүнг үнэлэх, тасралтгүй сургах, ажлын байрны ажиллах нөхцөлийг сайжруулах, осол гарах эрсдэлийг урьдчилан илрүүлэх, осол гаргаагүй ажил олгогчийг урамшуулах, нийгмийн даатгалын байгууллагын чиг үүргийг нэмэгдүүлэх зэрэг асуудлыг цогцоор шийдэх, хуульчлах нь өнөөгийн бодит хэрэгцээ болоод байна.

Түүнчлэн эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн бодлогыг хөгжүүлэх, хөдөлмөрийн чадвар алдалтыг хөдөлмөр эрхлэх чадамжид тулгуурлан тогтоох. Ингэснээр иргэнээ хөдөлмөрлөх дадал сэдэлтэй болгох, ажил олгогч нь ажилтны нийгмийн баталгааг хангахад хувь нэмрээ оруулдаг тогтолцооны шинэ чиг хандлагыг бий болгох шаардлагатай байна.

Мөн эрүүл мэндийн нөхөн сэргээлт хийх сувиллын тусламж үйлчилгээний хувьсах зардлыг даатгалын сангаас хариуцаж байгаа ч даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээгдэж буй эсэхийг хянах, үнэлэх зохицуулалтыг хуульчлаагүй. Нөхөн сэргээх эмчилгээ үйлчилгээг эрчимтэй үзүүлэх нөхцөл журам тодорхойгүй байгаа юм. Иймээс нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд үйлдвэрлэлийн ослын улмаас учирсан хохирлыг арилгах, хэвийн үйл ажиллагааг сэргээх зорилгоор сул зогссон хугацаанд болон хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосон ажилтнаа тохирсон ажлын байраар хангасан тохиолдолд шимтгэлийн чөлөөлөлт үзүүлэхээр тусгасан.

Мөн даатгуулагчийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төлбөрийг нэмэгдүүлж даатгалын сангийн тухайн жилийн шимтгэлийн орлогын 2 хувиас сэхэхгүй байхаар тусгасан.

Хөдөлмөрийн чадвараа алдсан тэтгэвэр авагчид протез, ортопедийн жишиг үнийг баримтлан эхний удаа 100 хувиар, дараагийн удаа 50 хувиар тооцон Даатгалын сангаас хариуцаж байсныг 3 жил тутамд 100 хувиар хариуцаж байхаар хуулийн төсөлд тусгалаа.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний урьдчилан сэргийлсэн ХАБ, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулсан ажил олгогчид шимтгэлийн хөнгөлөлтийг 3 жилд 10 хувиар тооцон үзүүлдэг байсныг 15 хувь болгон нэмэгдүүлсэн.

Хуулийн төсөл батлагдсанаар үйлдвэрлэлийн осолд өртсөн болон мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдаж, хөгжлийн бэрхшээлтэй болсон даатгуулагчид эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн үйлчилгээ үзүүлэх замаар хөдөлмөрийн зах зээлд бэлтгэх, тэдний нийгмийн баталгааг хангах нөхцөл бүрдэнэ.

Түүнчлэн ажил олгогчид шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх шалгуур үзүүлэлт тодорхой болж үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх, хяналт тавих, ослоос урьдчилан сэргийлэх мэдээллийн нэгдсэн сан бүрдэх юм. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй уялдуулан 3 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах юм.

УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

П.Анужин: Танилцуулга хийсэн Аюурсайхан сайдад баярлалаа.

Хуулийн төсөлтэй холбоотойгоор асуулт асуух гишүүдийн нэрсийг авъя. Бадарчийн Жаргалмаа гишүүнээр тасалж байна. Бадарчийн Жаргалмаа гишүүн асуулт асууна.

Б.Жаргалмаа: Мэдээж хэрэг энэ хуулийн төслийг дэмжиж байгаа. Би зүгээр нэг хэд хэдэн зүйл асуух гэсэн юм. Яг өнөөдрийн байдлаар Монгол Улсад протез, ортопедийн үйлдвэр ямар хэмжээнд байна вэ гэдэг асуулт.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэйгээ уулзах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангах ажил эрхлэх тэр боломжийг нь нээж өгөх асуудлаар бас тодорхой хэмжээний уулзалт, форум зөвлөгөөнүүдийг ингээд хийгээд явж байхад тэд нар юу хүсэж байна вэ гэвэл ажлын байртай байх, эргээд хэд хэдэн хууль дээр Төрийн худалдан авах ажиллагааны тухай хууль дээр ч гэсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг худалдан авах асуудал дээр иргэний болон ААН-ийн гэсэн нэр томъёоноос шалтгаалаад иргэд үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээ худалдах тэр боломжгүй болсон байна. Хөдөлмөрийн тухай хууль дээрээ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих зүйл заалтууд дээрээ 41 дүгээр гэж санаж байна. Тийм ээ. 144 дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг дэмжин төрийн байгууллагууд худалдан авах ийм зүйл заалт байгаа. Гэтэл яг түүн дээр иргэний болон ААН-ийн гэсэн нэр томъёоллоос шалтгаалаад бараа бүтээгдэхүүнийг худалдаж авах худалдаж чадахгүй байгаа ийм жишиг тогтчихсон байна.

Энэ дээр бид нар бас засвар хийх, шинэчлэл хийх зайлшгүй шаардлага байгаа гэдгийг бас Хөдөлмөрийн сайд өөрөө анхаарна биз.

Нөгөө талаар протез, ортопедийн үйлдвэр өнөөдөр Монголд устаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төв дээр нэг жижигхэн юу ажиллаж байгаа тийм ээ, үйлдвэр байгаа. Ямар ч ажлын байрны шаардлага хангахааргүй протез, ортопедийн үйлдвэрийнхээ байрыг бид нар авчихсан. Өөр байр оруулчихсан байгаа. Ганц мэргэжилтэн мэргэжлийн хүн нь өнөөдөр тэтгэвэртээ гарах болчихсон байгаа. Энэ мэт асуудал дээр анхаараач ээ гэдэг зүйлийг л хэлэх гэсэн юм. Яг энэ чиглэлээрээ бид нар энэ хууль дээр бас тодорхой хэмжээний тийм ээ зүйл заалтуудаас оруулах ёстой байх гэдэг саналыг хэлэхийн тулд үг авлаа. Тэгээд энэ дээр бас яг сайд өөрөө ямар байр суурьтай байгаа юм. Үгийг нь сонсьё. Тэгээд хуулийн төслийг дэмжээд явна.

П.Анужин: Аюурсайхан гишүүн хариулъя.

Т.Аюурсайхан: Жаргалмаа гишүүний асуултад хариулъя. Энэ Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд ажлын байраар хангах ийм зохицуулалтууд байгаа. Энэ хуулийнхаа энэ үүргийг биелүүлээгүй бол тодорхой хэмжээний төлбөр хураамж төлдөг. Мөн түүнчлэн энэ ажлын байраар хангахынхаа оронд тодорхой байдлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэсэн энэ бараа бүтээгдэхүүнийг худалдаж авах энэ үүргээ хүлээсэн байдаг. Энэ асуудлууд дээр яах вэ, энэ 2023 оноос эхлээд энэ салбарын хяналтын чиг үүрэг бас манай яам дээр ирсэн байгаа. Тэгэхээр энэ бас маш чухал ЗГ-ын шийдвэр гэж бодож байгаа. Манай яаман дээр салбарын хяналтын нийтдээ 18 хүний бүрэлдэхүүнтэй шинэ газар байгуулагдаад ингээд ажилдаа орсон. Үүний хүрээнд энэ хөдөлмөрийн хуулийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих, энэ үйл ажиллагаа бас ахиц дэвшилтэй, бодит үр дүнтэй болно оо гэж үзэж байгаа. Энэ чиглэлээр нэн ялангуяа энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг бас ажлын байраар хангах үүний зэрэгцээгээр ХАБ, эрүүл ахуйн чиглэлийн хууль тогтоомжийн зүйл заалт хэрэгжилт муу байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн энэ олдмол нөхцөл байдлаас үүссэн маш өндөр хувьтай 48 орчим хувьтай байгааг та мэдэж байгаа. Тэгэхээр энэ нэлээн зонхилох хэсэг нь мөн энэ ажлын байрны ХАБ, эрүүл ахуйн шаардлага энэ алдагдсанаас болж байгаа ийм нөхцөл байдал байгаа. Энэ чиглэлд мөн байгууллагууд төсвийнхөө тодорхой хэмжээг зарцуулах ёстой. Энэ мөн ялгаагүй хангалтгүй. Үүнийг бид нар салбарын хяналтын яаман дээрээ авснаар энэ хяналтыг нь тавьж зохих зардлыг нь зарцуулж үүний дагуу бас үр дүн гаргаж урьдчилан сэргийлэх энэ чиглэлийн ахиц хэвшил гаргана гэж тооцож байгаа.

Протез, ортопедийн үйлдвэрлэлийн нөхцөл байдал дээр би анхааръя.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төв дээр бас тодорхой хэмжээний үйл ажиллагаа явуулж байгаа. Үүнийг мөн үйл ажиллагааг нь сайжруулах мөн улсын хэмжээнд зөвхөн нийслэл биш аймаг орон нутгийн хэмжээнд бас энэ чиглэлийн үйлдвэрлэлийг бас дэмжих энэ чиглэлийг бас баримталж ажиллая гэдгээ танд хэлъя.

П.Анужин: Жаргалмаа гишүүн тодруулъя.

Б.Жаргалмаа: Баярлалаа. Аюурсайхан сайддаа. Тэгээд Хөдөлмөрийн тухай хууль 2022 оны 1 сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн байгаа. Нийгмийн бодлогын

байнгын хороо буюу манай энэ Байнгын хороон дээр Хөдөлмөрийн тухай хуулийн ажлын хэсэгт орж ажилласан, ихэнх гишүүд нь байгаа учраас би бас өнгөрсөн жил Нийгмийн болгон байнгын хорооны даргад бас хүсэлт тавьсан байгаа. Өөрөөр хэлэх юм бол Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих нэг ажлын хэсэг байгуулж өгөөч ээ, байгуулъя гэдэг ийм санал тавьсан. Өөрөөр хэлэх юм бол хууль хэрэгжээд 1 жилийн хугацаа өнгөрсөн. Зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэхээсээ илүүтэйгээр Хөдөлмөрийн тухай хууль дээр бид нар нарийн зааж өгсөн. Ажиллах ажлын байр, цагийн хөлс тийм ээ, гэрээлэн гүйцэтгэх мөн дадлагажигчаар ажиллах гэх маш олон зүйл заалтууд өнөөдөр хэрэгжихгүй байгаа. Энэ байдал дээр нэг хяналт тавья. Байнгын хорооноос ажлын хэсэг гаргаач ээ гэдэг ийм санал тавьсан байгаа. Энэ саналыг дахиж тавиад ажлын хэсэг гарч хяналт тавихдаа боломж байгаа болов уу гэдэг саналаа дахиад тавья. Баярлалаа.

П.Анужин: Хуулийн төсөлтэй холбоотойгоор гишүүд асуулт асууж дууслаа.

Хуулийн төсөлтэй холбоотой үг хэлэх гишүүдийн нэрсийг авъя. Үг хэлэх гишүүд байхгүй байна.

Бейсен гишүүн ороод ирлээ. Бейсен гишүүн хуулийн төсөлтэй холбоотой үг хэлнэ.

Б.Бейсен: Энэ асуулт асуух гэсэн юм, сая бас би хоцорч. Энэ үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний талаар ярья гэж бодож байна. Хувийн уурхайд ажиллаж байгаа нэлээн олон уурхайчид байж байна. Энэ дээр тэр нийгмийн даатгалын зарим нь төлөхгүй байгаа уурхайнууд ч байж байна. Эрүүл мэндэд нэлээн хортой тийм юмнууд ч байж байна. Энэ тал дээр жаахан анхаарч ажиллаад нийгмийн даатгалыг нь төлүүлэх тал дээр анхаарахгүй бол болохгүй нь.

Үйлдвэрийн осолд хувийн компанид ажиллаж байгаа улсууд дээр ерөөсөө үйлдвэр осол тухай урьд нь болохоор чинь хөдөлмөрийн чадвар алдалт 60 хувиар тогтлоо гэхэд 40 хувийг нь урд авч нөгөө тухайн байгууллага нь төлдөг тийм байсан шүү дээ. Одоо тэр хувийн компанид ажиллаж байгаа улсуудын үйлдвэрийн ослын юуг дээрээс төлөхгүй байна. Энэ хувийн компаниуд. Энэ дээр бас жаахан анхаарч ажиллаач ээ гэж хэлмээр байна.

Дараа нь энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, иргэдийн асуудал байна л даа. Баян-Өлгийд бусад аймагт ч байгаа байх. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэдээ сургалтын төв гээд байж байна. Тэнд хэдэн багш тэгээд л нөгөө галч тэгээд төвийн юунд холбосон байна. Гэтэл нөгөө улсад нэг арван долоохон сая төгрөгийн төсөв байдаг юм байна. Тэгэхээр чинь энэ хотын нөгөө хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төв дээр тэрбум хэдэн зуун сая төгрөг тавигдсан.

Хөдөөгийн юмнууд дээр бас анхаарахгүй үнэхээр аргагүй хөгжлийн бэрхшээлтэй юунууд байж байна. Хөгжлийн бэрхшээлтэй боловч ихэнх нь дандаа ядуу айлын хүүхдүүд. Бусад амьдрал гайгүй тийм улсууд тэнд ерөөсөө яахгүй шүү дээ. Тэр тал дээр нэг анхаараад ажиллаач ээ гэж нэг хүсэлт тавимаар байна.

П.Анужин: Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор гишүүд үг хэлж дууслаа.

Санал хураалт явуулна.

Монгол Улсын ЗГ-аас 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалтад оролцсон нийт гишүүдийн 60 хувь дэмжлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанд илтгэх гишүүнээр УИХ-ын гишүүн Бадарчийн Жаргалмааг томилж байна.

Дараагийн асуудалдаа оръё.